



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/09

Булган сум

**"Визит Булган-2023" форум  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны XII/03, 2022 оны XII/21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/08 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд "Визит Булган-2023" аялал жуулчлалын форумыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсугай.

2. Аялал жуулчлалын форум зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дарга: Г. Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Э. Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б. Анхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах албаны ажилтан)

А. Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Ц. Ганчимэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Г. Бямбажаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С. Алтанзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

3. Форум зохион байгуулахад шаардагдах 9,317,800 (есөн сая гурван зуун арван долоон мянга найман зуу) төгрөгийн зардлын тооцоог хавсралтаар баталж, байгаль

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6322011160

орчныг хамгаалах байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4. "Визит Булган 2023" форумын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган, чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсэг (Г.Давааням)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 12-ны өдрийн А/09 дугаар  
захирамжийн хавсралт



**БУЛГАН АЙМГИЙН “ВИЗИТ БУЛГАН 2023” ФОРУМЫН  
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

<b>1.Илтгэгчдийн төлбөр</b>				
№	Зардлын утга	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Үнэ /төг/
1	"Mongolian guide tour" ХХК-ийн захирал Ч.Буянбадрах	294200	1	200000
2	Ган-Од	294200	1	200000
3	БОАЖЯ-ны мэргэжилтэн	122200	2	244400
4	Ачааны машины түрээс	400000	1	400000
5	Илтгэгчдийн галт тэрэгний тасалбар (ирэх, явах)	94200	2	188400
<b>Дүн</b>				<b>1232800</b>
<b>2.Илтгэгчдийн байрны зардал:</b>				
№	Зардлын утга	Нэгж үнэ	Хоногийн тоо	Нийт
1	Зочдын байрны зардал	110000	18	1980000
<b>Дүн</b>				<b>1980000</b>
<b>3.Хоол, цайны завсарлагааны зардал</b>				
№	Зардлын утга	Нэгж үнэ	Хүний тоо	Үнэ /төг/
1	1.20-ны өдрийн хоол	21000	128	2676000
2	Цайны завсарлага 1	5000	120	600000
3	Цайны завсарлага 2	5000	120	600000
4	Ус	1000	120	120000
<b>Дүн</b>				<b>3996000</b>
<b>4.Бусад зардал</b>				
№	Зардлын утга	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Үнэ /төг/
1	2 ажилтны томилолт (ХЖТ)	44000	4	176000
2	Нэг удаагийн хэрэгсэл		240	100000
3	Хогийн уут	5000	15	75000
4	Хэвлэлийн зардал	100000	1	100000
5	Зураг наах наалт	9000	2	18000
6	Хөлтэй самбар	65000	2	130000
<b>Дүн</b>				<b>599000</b>
<b>5. Унааны зардал</b>				
№	Зардлын утга	км-ийн зай	литр*нэгж үнэ	Үнэ /төг/
1	Машин (БОАЖГ) автобус Булган-Хялганат-Чулуут- Хялганат-Булган	445	75*3940	300000
2	Машин (БОАЖГ) 76 Булган-Хялганат-Эрдэнэт- Хялганат-Эрдэнэт-Хялганат- Булган	500	900*3940	360000
3	Машин (ХБТХОХ)	430	56*2850	360000
4	Театр машин	280	35*2850	100000
5	Францын ажлын хөлс	495	89*3940	390000

Дүн		<b>1510000</b>
<b>ЗАРДЛЫН НЭГТГЭЛ</b>		
1	Илтгэгчдийн төлбөр	1232800
2	Илтгэгчдийн байрны зардал	1980000
3	Хоол, цайны завсарлагааны зардал	3996000
4	Бусад зардал	599000
5	Унааны зардал	1510000
<b>Нийт дүн</b>		<b>9317800</b>